



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 04 сарын 03 өдөр

Дугаар А/67

Мандалговь

Албан тушаалын тодорхойлолт
батлах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3.2 дахь заалт, “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2016 оны 9 дүгээр тогтоолын 1, 2 дахь заалт, “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2019 оны 276 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 5.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоо батлах тухай” А/383 тоот захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Засаг даргын туслах (шуурхай мэдээлэл) бүс нутгийн асуудал хариуцсан ажилтны албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр, Мэдээллийн технологийн ажилтны албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар, Гадаад харилцааны ажилтан, Засаг даргын хэвлэлийн төлөөлөгчийн албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар, Олон нийттэй харилцах ажилтны албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр, Хэвлэл мэдээллийн ажилтны албан тушаалын тодорхойлолтыг 5 дугаар, Цахим архив, техникийн операторын албан тушаалын тодорхойлолтыг 6 дугаар, Албан хэрэг хөтлөлтийн ажилтны албан тушаалын тодорхойлолтыг 7 дугаар, Аюулаас сэрэмжлүүлэх цогцолборын ажил хариуцсан ажилтны албан тушаалын тодорхойлолтыг 8 дугаар, Хууль эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн сан хөмрөгийн эрхлэгч, архивын ажилтны албан тушаалын тодорхойлолтыг 9 дүгээр хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Батлагдсан албан тушаалын тодорхойлолтыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ЭРДЭНЭСҮРЭН



482060271